

1990 ОНООС ХОЙШХИ МОНГОЛЫН БУДДЫН ШАШНЫ СҮСЭГТНҮҮДЭД СҮМ ХИЙДИЙН ЗҮГЭЭС ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Д.Оюунгэрэл, (Доктор PhD)

Б.Энх-Амгалан (Магистрант)

МУИС, ШУС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: 1990 оны ардчилсан өөрчлөлт, сүм хийдийн сэргэлт, сүсэгтэн олон, нийгмийн оюун санаа, шашин шүтлэгийн эрх чөлөө

Товч утга: 1990 оноос хойш Монголын Буддын сүм хийдийн үйл ажиллагаа дахин сэргэж, сүсэгтэн олон ба сүм хийдийн хоорондох харилцаа эргэн бэхжиж, сүсэглэх эрх чөлөө хангагдсан боловч Буддын сүм хийдийн зүгээс нийгмийн оюун санаанд дорвитой нөлөө үзүүлэх тал дээр хангалтгүй байгаа нь сүм хийдээс сүсэгтнүүддээ нөлөөлөх аюуллагаа сул байгаатай холбоотой. Буддын сүм хийдийн үйл ажиллагааг сүсэгтнүүдэд зориулан идэвхжүүлэхийн зорилго нь нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, залуу үеийг энэрэнгүй, асрангуй, тэгш сэтгэлтэй, хүнлэг хүн болгож хүмүүжүүлэх, бодь сэтгэлийг олохын тухайд Буддын сургаалыг залуу үед эзэмшүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, өвчин зовлонд нэрвэгдсэн ард иргэдэд туслалцаа, сэтгэлийн дэм өгөх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд оршино.

* * * * *

Монгол дахь Буддын шашин нь нийгмийн хувьслын янз бүрийн цаг үеийг туулсаар 1990 онтой золгосон билээ. Өнгөрсөн зууны эхний мөчлөгт Коминтерний явуулгаар манай улаан засаг сүм хийдийг нурааж, судар номыг шатааж, лам хуврагуудыг хөнөөж, шашин суртахууныг хорьж, улмаар Бурханы шашины нөлөө Монгол газарт нэн доройтсон юм. Ер нь бол өнгөрсөн зууны 40-өөд он гэхэд манай улсад байнгын ажиллагаатай сүм хийд бараг үгүй болжээ. 1930-аад оны дундаас эхэлсэн Бурханы шашиныг хориглох ардын засгийн төрөл бүрийн арга хэмжээ, тушаал, шийдвэрүүд нь биеллээ олж, лам нарыг хэлмэгдүүлэн, хос ёсны сургаалыг монголчуудын оюун санаанаас бүрмөсөн мартуулсан гэж хэлж болно. Сүсэгтэн олон ханцуйдаа нууцаар залбирч, бурхан шүтээнээ уул хаданд өргөж, хувраг лам нарын олонх нь хэлмэгдэж, "шашин үндсээ хамгаалах" зорилготой эхэлсэн тэмцэл нь аажимдаа харийнхны явуулгаар шашнаа устгах, үндэстнээ хөнөөх үйл үйлдээлд хүргэсэн бөлгөө.

1990 онд манай оронд ардчилсан хөдөлгөөн өрнөж, коммунист тоталитар дэглэмийг унагаж, Монгол Улс эрх чөлөөт ардчилсан улс болох замдаа оров. Монгол Улс 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиараа “Эх орондоо хүмүүнлэг, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх”-ийг эрхэм зорилгоо болгож, иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг эрх зүйн баримт бичгээрээ тунхаглаж өгсөн юм. 1993 онд Монголын парламент “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хуулийг баталж уг хуулиар төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулахаар заасан байна. Тус хуулийн 4 дүгээр зүйлд “Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй” хэмээн заасан. Ардчиллын 20 гаран жилийн дотор ийнхүү уламжлалт шашныг сэргээх талаар монголчууд багагүй амжилтанд хүрсэн юм.

1992 онд Шинэ Үндсэн хууль батлагдаж гарах хүртэл Монгол Улсад Гандантэгчэнлин

хийд ганцаар 130 орчим ламтайгаар бурханы шашны үйлийг эрхлэн явуулж байв. 1838 онд анх нээгдсэн Гандантэгчэнлин хийдийг 1938 онд хаагаад 6 жил орчим болж, 1944 оны 7 дугаар сарын 1-нээс үйл ажиллагааг нь дахин сэргээж, Найдангийн Эрдэнэпил (1889-1960) гавжийг хамба болгон, бурхан шашны үйлийг явуулахаар төрөөс зөвшөөрсөн байна. Өнгөрсөн хугацаанд Эрдэнэпил гавжаас залган, номч мэргэн гавж Самаагийн Гомбожав (1901-1980), Хархүүгийн Гаадан, гавж Сугирын Дагвадорж, гавж Төмөрийн Дамдинсүрэн нар удирдаж байсан бол өнөөдөр гавж Дэмбэрэлийн Чойжамц Гандантэгчэнлин хийдийн хамба ламаар ажиллаж байна.

1920-иод онд “Шашин үндсэнд харшлах харгис дайсныг дарж”, “Шашныг ариунаар мандуулах”, “Алдагдсан эрхээ эргүүлэн авах” гэх мэт зорилт тавин тэмцэж эхэлсэн монголын хувьсгалчдыг 1940 он гэхэд олонхийг нь хөнөөж, ард олны шашин шүтэх эрхийг боогдуулж, хутагт хувилгаад тодруулахыг хориглож, ядуу доорд ангийн лам нарыг албадан хар болгож, эрдэмт дээд лам нарыг хэлмэгдүүлэн, капиталист бус замыг улс орны хөгжлийн гол зорилт болгон дэвшүүлж “цэгцэлжээ”. Шашин номын сургаалыг олонд гэгээрүүлэх үйл тасалдсанаар, хүмүүсийг элдэв хэрэг зөрчлөөс сэргийлэх номын зөөлөн арга үгүй болж, бүх асуудлыг зөвхөн засаг төрийн хууль, дүрмээр шийдвэрлэх болсон юм. Тухайлбал: 1930-1940-өөд оны хэлмэгдүүлэлтийн дараа мал, мах, ноос, арьс, шир, сүүний ноогдсон төлөвлөгөө биелүүлээгүй, төлөвлөгөөт ноогдол дутаасан хэргээр шоронд орсон бээцгэр малчин өвгөд 1954 он гэхэд суллагдан шуудангийн машинд дайгдан сумын төвд ирж байхыг харсан өтгөс өнөө дал гаруй настай хууч хөөрч сууна. Бас төр засгийн тухай элдэв цуу үг ярьсан гэж шийтгүүлсэн нь ч олон гэнэ. Аливаа бүхнийг төрийн хуулиар шийдэх, хүчээр зөв замд оруулах нь өрөөсгөлдөж, хатуу тогтолцоог гол болгох эрмэлзэл нь ямагт зөв гэж үзэхэд бэрх билээ.

Арц, хүжийн анхилуун үнэр, бүрээ бишгүүр, хонх дамрын дуу тасалдан, шашингүй он жилүүд 60 гаруй жил үргэлжилсэн юм. 1990-ээд онд ардчиллын салхи хаагдмал асан зарим үүдийг нээж, олны сүсэг шүтлэгийн хэрэгцээг хангах сүм, хийд орон олноороо сэргэн байгуулагдаж эхлэв.

Бурханы шашны сүм хийд, лам хуврагийн тоо нэмэгдэж, шашны дээд, дунд сургууль нээгдэж байв ч хийдүүдийг нэгтгэн зохицуулах, удирдах, толгойлох эзэнгүй байсаар байна. Монголын шарын шашны тэргүүн Богдыг залах хэргийг 1924 оноос тасалдуулсанаар ардчиллаас хойш сэргэн бий болсон сүм хийд нэгдмэл удирдлагагүй, өөр өөрийн толгой мэдсэн нэгэн компани мэт боллоо. Шашин шүтлэг чөлөөтэй болсоноор хос ёсны уламжлал бүрнээ сэргэсэн хэрэг хараахан биш ажээ. Олон шашин зэрэгцэн дэлгэрэх нь сүсгээр эвлэрэн нэгдэх бус, харилцан сөргөлдөх шалтаг болж, нийгмийн дотоод эв нэгдэл сулрахын шалтгаан гэх үг түүхнээ гардаг.

Орчин үед бурханы шашныг албан тушаалтан дээдсүүд зөвхөн өөрсдийгөө сурталчлах хэмжээнд авч үзэж байгааг бид бүхэн мэдэх билээ. Төрийн удирдлагууд цагаан сараар золгох үедээ Гандантэгчэнлин хийдэд очиж, Жанрайсиг бурханд мөргөж байгаа нь сүсэг шүтлэгийн илрэл бус, олон түмэнд өөрсдийгөө сурталчилж байгаа хэрэг гэлтэй. Төрийн томчуул элдэв ажлыг эхлүүлэх, дуусгах, нээлт хийж тууз хайчлах сэлтэд лам залах зэрэг мэт нь ч мөн л өөрсдийгөө сурталчлах нэгэн хэлбэр болой. Одоогийн төрийн дээдсийн энэ мэт үйл нь Бурханы шашны “Хос ёс”-оор төрөө засаж, түмнээ хөтлөх уламжлалт сургаал номлолыг зохих ёсоор нь хийж буй хэрэг бус аа.

Төр, шашныг холилгүй, тэгшид явуулах бодлогыг орхиж, өрөөсгөлдсөн нь монгол төрийн уламжлал тасран гадны хавчилтад орж аргагүйдэн үйлдсэн хэрэг байсан нь коммунист сурталыг орхиж, ардчилсан ёсыг баримтлах болсон шинэ зуунд хүн ардын шүтэх сүслэх эрхийг сэргээж, сүм хийдийг шинээр байгуулан хутагт, хувилгаадыг тодруулан залах, ном судрыг хэвлэн түгээх ажил сэргэх шинэ үе эхэлсэнээр нотлогдож буй. Ийнхүү Монгол оронд ардчилал шинэчлэлийн үр дүнд эхэлсэн шинэ зууны босгон дээр шашин шүтэх сүслэх эрх,

эрх чөлөө нээлттэй болж, 70 гаруй жилийн өмнө сүйдсэн бурханы шашны хийдийн буурин дээр арц хүжийн анхилуун үнэрээр ариусгах сүм, хийд, дацан сургууль нээгдэж бурханы шашин дахин сэргэж эхлэв. Шашны сэргэлт дэлгэрлийн энэ үеийг Монгол дахь бурхан шашины дэлгэрэлтийн дөрөв дахь буюу шинэ үе гэж нэрлэж болно.

Чухамдаа манай оронд бурханы шашин нэн аажим нэвтэрч, нэг үе бууран доройтовч, огт тасран мөхсөнгүй, эргэн сэргэж, мандал буурлыг үзсээр иржээ. Шинэ Үндсэн Хууль батлан, шашин шүтлэгийг чөлөөтэй болгосон нь шашин дахин сэргэн хөгжих чухал ач холбогдолтой болов. 1992 оны 1 дүгээр сарын 13-нд баталсан “Монгол Улсын Үндсэн Хууль”-ийн Есдүгээр зүйлд:

“Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэнэ.

Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа явуулж болохгүй.

Төр сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна” гэсэн заалт оржээ.

Уг хуулийн 16 дугаар зүйлд зааснаар “Монгол улсын иргэд, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө”-тэй болсон байна. 1993 онд Улсын Их Хурлаар “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хууль батлав. Тийнхүү монгол оронд ард олны сүсэг шүтлэгийн олон жилийн хориг тавигдлаа.

Бурханы шашин сүсэгтэн олныг гэгээрүүлэх үйлийг явуулах бүх нөхцөл цогц бүрдлээрээ тавигдсан юм. Дээр үед сүм хийдэд хурал ном айлдаж байсан зарим өтгөс лам нар хийддээ эргэн ирж, хуучин сүм, хийдийг сэргээх, шинээр шашны дээд боловсролтой лам нарыг бэлтгэх болов. Мөн 1990 оноос нийслэл хотноо шашны дунд сургуулиуд байгуулагдав.

Дэлхийн бурханы шашны тэргүүн Дээрхийн гэгээн Далай лам Монгол оронд хэд хэдэн удаа морилон сүсэгтэн олонд сургаал номлолоо айлдав. 2011 оны байдлаар манай оронд буддын шашны 170 сүм хийд дацанд 5000 лам хувраг үйл ажиллагаа явуулж суралцаж байна¹. Буддын шашин сэргэхэд сүм, хийд, лам хувраг олшрох төдийгүй хутагт хувилгаадыг тодруулах уламжлал сэргэв. Өнөө Заябандида Лувсанданзанпүлжинжигмэд, Эрдэнэ бандида хутагт, Жалханз хутагт, Манзушри хутагт, ламын гэгээний VIII дүр Данзанжамбалцойжишинин, Говийн ноён хутагт зэрэг шинэ үеийн хутагт гэгээнтнүүдийг тодруулан, зарим залуу гэгээнтнүүд далай ламын ивээлд багтан, Энэтхэг улсын Дармасала хот болон Карнатка мужид, Төвдүүдийн байгуулсан Бэрээвэн хийдийн Гоман дацанд манай нэгэн зуу илүү лам, 3-4 залуу хувилгаан суралцан шашны боловсрол эзэмшиж байна. Монголын шашны тэргүүн Богд нь гурван зууны уламжлалт түүхтэй Далай ламаас тодруулсан Монголын шарын шашны дээд тэргүүн мөн. Төвд оронд тодорсон IX дүгээр Богдыг Монголын шашны тэргүүнээр залах хэргийг хорь шахам жил мэтгэлцсээр 2011 оны 11 сарын 02-нд ёсчлон гүйцэтгэсэн. IX богдыг монголчуудын шашны тэргүүнээр ёсчлон залах нь зөвхөн манай улсын бурханы шашны хэрэг бус, Бурхан шашиныг орчин үеийн олон улсын нөхцөлд хөгжүүлэхэд олон талын ач холбогдолтой хэрэг юм.

Тиймээс Богдыг шашны тэргүүнээр залах нь манай улсыг нийт монгол угсаатны шашны төв хэмээн баталгаажуулах шашин төрийн ач холбогдолтой. Монгол угсаатан сүсэгтэн олон Богдод мөргөх нь нэмэгдэж, мөргөлчдийн тоог нэмэгдүүлснээр эдийн засгийн хувьд ч өгөөжтэй юм. Монгол туургатны бүрдэл буриад, халимаг, тува, ойрд (ОХУ-ын бүрдэлд буй Алтайн хязгаар, Горно-Алтай гэх хоёр жижиг улс) нар бурханы шашнаа сэргээн сүм дуган барьж лам хуврагуудаа сурган бэлтгэж байхын зэрэгцээ Халимагийн ерөнхийлөгч асан Кирсан Улымжинов Далай ламыг өөрийн нутагтаа суухыг урьж байсан. Буриад нар Итгэлийн Дашдорж хамба шүтээндээ дулдуйдан шашны төв болохоор горилж байна. Өвөр-Монгол, Халимаг нар нэлээд эртнээс хутагт хувилгаадыг тодруулан залж эхлэв. Харин тэдэнд өөрийн Богд байсангүй. Буриадын, Тувагийн, Халимагийн, Өвөр Монголын Богд

¹ Үндэсний шуудан сонин. 2011 оны 5 дугаар сарын 03. №105

гэж ерөөсөө байгаагүй, нийт Монгол туургатны бурхан шашны нэг л тэргүүн байж ирсэн уламжлалтай. Монгол орон бол зөвхөн монгол угсаатны шашин шүтлэгийн тэргүүнийг залсан нутаг төдийгүй 1970 оноос өнөөг хүртэл “Азийн Буддистуудын Энх Тайваны Бага Хурал” гэдэг буддын шашны зүтгэлтнүүдийн хамтын ажиллагааны байгууллагын төв болсоор ирсэн билээ. Гандантэгчинлэн хийдийн тэргүүн хамба асан Номч мэргэн гавж Самаагийн Гомбожавын (1901-1980) санаачлагаар Япон, Шри Ланка, Энэтхэг, Балба, Вьетнам, Малайз, Сингапур, ЗХУ-ын буддистуудын уулзалт Улаанбаатар хотноо болж энэ байгууллагыг бий болгосон нь өнөөг хүртэл хагас зууны туршид манай улсын нийслэлд төвлөрч үйл ажиллагаа явуулсаар байна.

Тийнхүү бурханы шашин нь зөвхөн монголчуудын төдийгүй Ази тивийн ард олны эв нэгдэл нэгэн хөшүүрэг болсоор байгаа тул Монгол орны шашны тэргүүн нь үүнд ихээхэн чухал нөлөөтэй болох юм. Энэ байгууллагын далбаан дор манай оронд бурханы шашны зүтгэлтний шинэ үеийнхнийг бэлтгэх шаардлага хэрэгцээг 1990-ээд оноос өмнөх Монголын нам, засаг анхааран зөвшөөрсөн ажээ. Гандантэгчинлин хийдийн хамба номч мэргэн гавж С.Гомбожав, Буриадын бурханы шашны тэргүүн Гомбоев нарын санаачлага зүтгэлээр Улаанбаатарт 1970 онд Шашны дээд сургууль байгуулж, 1970 оны 9 дүгээр сарын 27-нд анхны 30 оюутантайгаар үйл ажиллагааг нь эхлүүлжээ. Энэ сургуульд хуучнаар Зөвлөлт Холбоот Улсын нутаг дахь бурхан шашинтны шинэ үеийнхнийг бэлтгэх бодлого хэрэгжиж, буриадаас залуус ирж суралцаж байсан байна. Өнөөгийн Оросын Холбооны Улсын бурханы шашинтны тэргүүн Дамба Аюушеев энэ сургуулийг төгсчээ.

Шашин шүтэх эрх чөлөө нээгдсэнээр тус сургуульд суралцагсадын тоо өссөн юм. Хутагт, хувилгаадын хойт дүрийг тодруулах, мөн хутагтуудын зохиол бүтээлийг судлах, мэлмий гийсний ойг нь тэмдэглэн эрдэм шинжилгээ судалгааны хурал хийж, ном бүтээлийг нийтийн хүртээл болгох ажил эрчимжсэн. Буддизмыг судлах, сурталчлах нь чөлөөтэй болж, буддын шашны ном зохиол цөөнгүй хэвлэгдэж, монгол Данжуурыг кирилл монгол үсгээр хэвлэж эхлэв. Гэвч дэлхийн томоохон шашны нэг, Монголын дийлэнх сүсэгтэн олны шүтдэг бурханы шашныг эсэргүүцэгч хүчин дэлхий дахинд өөрийн үзэл бодлоо ил, далд ямар нэг байдлаар илэрхийлж байгааг бид умартах ёсгүй юм.

Маркс-Лениний сургаалаар замнах нийгэм журмын мөрөөдөл замхарч, оюун санааны их хоосрол үүсэв. Янз бүрийн үзэл баримтлал бүхий олон намын тогтолцоо бий болов. Эрх баригч МАХН-ын үзэл баримтлал нь нэг үе Нагаржуна гэгээний төв үзэл гэгдэж байлаа. Үзэл баримтлал, шашин сурталын энэ орон зайг дүүргэхээр олон шашны янз бүрийн урсгал нэвтрэн орж ирж, улс төрийн олон намууд шашны сэдвээр мэтгэлцэх, өрсөлдөх болж, манай оронд протестант, мормоны сүм цуглаанууд, католик шашны төв Ватиканы сүм, Бахайн, Ананда-Марга, Мусульманы гэх мэт цөөн бус шашны сүм хийд хэдийнээ суурьшжээ.

Гэхдээ монголчуудын дийлэнх олонх нь бурханы шашнаа дээдэлсээр байна. Эрдэмтэн Дандаа төр ёсны сургаалдаа “Монголчууд эрдэм, боловсрол соёл иргэншлийг хөгжүүлэхийг эрхэм болгохдоо, бусад үндэстний төр ёсны сургаалыг дуурайх юмуу хуулбарлах нь хангалтгүйгээр үл барам түүгээр дамжиж бага буурай үндэстнийг уусгах үзэл санаа нэвтэрч үлэмж хор уршиг тарьдаг” хэмээн учирлан сургамжилсан нь өнөө үеийн бидэнд чухал сануулга болж байгааг анхаарах хэрэгтэй. Монголчуудын сүсэглэдэг бурханы шашны дээд тэргүүн Дээрхийн Гэгээнтэн Далай Лам Хятадын коммунист засгийн мөрдлөгөөс зугатаж, эх орноосоо дайжин дүрвээд нэгэнт хагас зууныг барж, төрөлх орондоо очих эрхгүй цагаач болж, нутагтаа үлдсэн бурханы шашинт төвөдүүд ил далд гадуурхагдах болов. “Хятадын коммунист намын төв хороо Банчин Богдыг томилж Ажаа гэгээнийг түүний багш бол хэмээсэнд тэрээр сэм оргож Америк улсад очсон”² билээ.

Сүүлийн жилүүдэд уламжлалт биш шашнууд Монгол Улсад дэлгэрэн хүмүүсийн

² Ажаа гэгээн. “Цагийг бэлэгдэгч Наран Чөлөө”. УБ., 2009. 223 дахь тал

сэтгэлийг сүсэг, итгэл бишрэлийг татах болов. Өнөөгийн улстөрийн гол хөдөлгөгч хүчин болсон олон ургальч суртлаар монголчуудын оюун санааны эв нэгдлийг хангах боломжгүй нь өнгөрсөн 20 жил нэгэнт ойлгогдсон бол нийт олны эв нэгдлийн нэг хөшүүрэг нь нэгдмэл шүтлэгтэй байх явдал болно. Монголчуудын шашин шүтлэгийг нэгдмэл биш болгох нь тийм ч сайн хэрэг биш хэмээн үзэж байна.

Уламжлалт бус шашны сүм хийдүүд өргөл, өглөг, хоол хүнс өгч, ном хэвлэл үйлдвэрлэн тарааж, суртал ухуулга хийж, мөн газар худалдан авч, том сүм хийд барьж, барилга байгууламжийн зохиомж хийцээрээ шалгаран шагнал урамшуулал авч, хүүхэд асрах, хичээл заах нэрээр шашин суртал номлож, нийт бурханы шашны сүсэгтнүүдэд илүү нөлөөлөхийг чармайсаар байна. Хожмын өдөр олон намын үзэл баримтлалын зөрчилдөөнөөс олон шашны үзэл сурталын зөрүү илүү болж Монголчуудын эв нэгдлийн эсрэг хүчирхэг хөшүүрэг болохыг үгүйсгэх аргагүй.

Дээрхийн гэгээн XIV Далай лам “Бид шинжлэх ухааны хөгжил, амжилтанд дэндүү их найдвал юу болох вэ гэдгээ бодох учиртай. Жишээ нь: шашны нөлөө багасах тусам амьдралд биеэ хэрхэн авч явах вэ гэдэг талаарх хүмүүсийн итгэл улам буурдаг. Өнгөрсөн үед шашин хийгээд ёс зүй маш дотно нягт уялдаа холбоотой байлаа”³ хэмээн айлджээ.

Өнгөрсөн хорин хэдэн жилд Монголд буддын олон шинэ сүм байгуулагдав. Ингэснээр бурхан шашины сүм хийдийн үйл ажиллагааны цар хүрээ өргөсөж, сүсэгтнүүдийн дунд буддын шашин нийгмийн үүргээ гүйцэтгэх боломж бүрдсэн юм. Тухайлбал, Монголд сүүлийн жилүүдэд Бакула Ринбүүчийн байгуулсан Бэтүб хийд, Гүр Даваа Ринбүүчийн сэргээсэн Амарбаясгалант хийд, Банчин Ой бурул ринбүүчийн байгуулсан Гүнчэв Жамбалин хийд, Тэрэлж дэх Арьяабал бурханы сүм, Зопа багшийн байгуулсан нийслэл хот болон Дархан хот дахь Махаяна төв, Гандантэгчилэн дэх Идгаачойнзонлин хийд, эмэгтэйчүүдийн Дулмаалин хийд, монголчуудын байгуулсан Зүүн хүрээ хийд, Дашчойлин, Манба дацан, Ловон Бадамжунай бурханы нууц тарнийн хийд, Пунцоглин, Ламираан хийд, сэргээн босгосон Дамбадаржаалин хийд, Хажид, Дарь эхийн хийдүүд сүсэгтнүүдэд чиглэсэн буяны ажиллагаагаа явуулж байна. Мөн 21 аймаг болон бусад сумдад буддын сүм хийдүүд олноор байгуулагдав.

Эдүгээ Монголд буддын 170 гаруй сүм хийд, дацанд 5000 лам хуврага байна⁴ гэсэн мэдээ бий. Сүүлийн жилүүдэд Энэтхэгийн Гомон дацанд арав гаруй жил бурханы ном үзсэн эрдэмтэй монгол залуу лам хуврагууд сургуулиа төгсөж ирээд эх орондоо бурханы ном айлдаж буяны үйлсэд зүтгэж явна.

Баруун зүгт Ховд аймагт Гандан Пунцаг чойлон хийд, зүүн зүгт Хэнтий аймагт Балдан Бэрээвэн хийд, өмнө зүгт Дорноговь аймагт Равжаа хутагтын төв, Хамрын хийд, Равжаа хутагтын Шамбалын орон, хойд зүгт Сэлэнгэ аймгийн нутагт Амарбаясгалант хийд, Дархан-Уул аймагт Бурхан багшийн сэрэг дүр, Улаанбаатар хотод Зайсан толгойн орчим Гүр Даваа Ринбүүчи болон Солонгосын буддын хамба ламын хандиваар Бурхан багшийн өндөр сэрэг дүр зэргээр Монгол орны өнцөг булан бүрд бурхан шашины сүм хийд, байгууллага төвүүдийг бүтээн босгоод байна.

2010 онд монголын сүсэгтэн эмэгтэй Оюун их хэмжээний хөрөнгө хувиасаа хандивлаж, Амарбаясгалант хийдийн орчим Богд лам Зонхавагийн алтадсан том сэрэг дүр, Богд ламын итгэлт шавь Хайдав, Жалцавчи нарын дүр бүхий цогцолборыг богино хугацаанд бүтээн байгуулсан нь монгол хүний итгэл сүсэг ямар их хүчтэй байгааг нотолсон. Монголд Дээрхийн гэгээн 14 дүгээр Далай лам долоон удаа залран ирж бурханы ном айлдаад байна. Монголд 9 дүгээр Богд Жавзандамба хутагт, Зопа римбүүчи, Банчин Ойбурул римбүүчи, Жадоримбүүчи, Саж Тризин римбүүчи, Ризон ринбүүчи, Чодэн римбүүчи, Дэнма Лочо

³ Дээрхийн гэгээн XIV Далай лам “Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй” УБ., 2001. 18 дахь тал

⁴ “XXI зууны Монголын нийгэм: хөгжил, өөрчлөлт, хандлага” МУИС-ийн социологийн судалгааны дүн. МУИС 2013

римбүүчи нарын олон эрдэмт лам багш нар айлчилж ном буяныг үйлдэж монголын сүсэгтэн олонд ном айлдаж, авшиг, ван, лүн өгсөөр байна.

Хорин жилийн саад эсэргүүцлийг давж VIII Богд гэгээнтэн Монгол Улсын иргэн болсон нь сүсэгтэн олны хувьд том үйл явдал боллоо. Ийнхүү монголчууд 90 жилийн дараа бурханы шашныхаа тэргүүнтэй боллоо. Непалын гэгээнтэн Зопа римбүүчийн байгуулсан “Махаяна” төв нь монгол залуучуудын дунд англи хэл заах, буддын ном судрыг монгол хэл дээр хөрвүүлж үнэ төлбөргүй тараах, бурханы сургаалыг үнэ төлбөргүй номлох, хичээл сургалт явуулах, ядуу хүмүүст хандивын буяны ажил зохиох зэрэг олон талт үйл ажиллагаа явуулснаар олон монгол залуучууд буддын шашныг ойлгож, бурханы сургаалын мөн чанарыг ухаарч эхэлсэн билээ. Монголын дуучид үндэсний шашнаа сурталчилж байна. Бурханч лам Г.Пүрэвбат багшийн бүтээн туурвисан буддын шашны зураг, бурхадын хөрөг, суварга, бусад олон бүтээл ном монгол төдийгүй өрнөдийн судлаачид, жирийн хүмүүсийн анхаарлыг татах болов. Г.Пүрэвбат багшийн байгуулсан “Лавайн эгшиг” FM радио нь нийслэл хотын залуучуудын сонсох дуртай радио долгион болоод байна.

Эдүгээ Богд ламын туурвисан “Ламримченмо” судар, “Ламрим” судрыг тайлбарласан Павонха болон Патрул римбүүчийн тайлбар ном, Шантидева гэгээнтний “Бодьсадын явдалд орохуй” зэрэг гайхамшигт судруудыг монголын эрдэмтэн лам доктор Т.Булган, бурханч лам Г.Пүрэвбат, шунлайв гавж С.Гантөмөр, лам Ц.Сансарбат нар төвд хэлнээс эх монгол хэл дээр шинэ кирилл бичигт хөрвүүлэн олны хүртээл болгоод байна. Бадамжунай бурхан, Адиша, Дилов, Нарова, Миларайб, Нагаржуна гэгээнтэн, Далай лам багшийн ном, сургаалуудыг шинэ монгол бичигт хөрвүүлсээр байна.

Өнгөрсөн 20 гаран жилийн турш дунд сургуулийн хөтөлбөрт үндэсний уламжлалт соёл, шашны талаар юу ч заадаггүй байсныг саяхан өөрчилж, Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар иргэдийн саналыг сонсч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарч, дунд сургуулиудад үндэсний соёл, шашин зан үйлийн талаар “Монголын уламжлалт сэтгэлгээ” гэсэн шинэ хичээл сурагчдад заах болсон нь чухал үйл явдал болж байна. Ийнхүү өнөөгийн Монгол орноо бурханы шашин дөрөв дэх удаагаа дэлгэрэн хөгжих сайхан боломж бүрдэж байна.

Бурханы шашинд хүн өөрийн сэтгэлийн гэм буюу нисваанисыг дараад магад гарахуй сэтгэлийг үүсгээд, тэгш сэтгэл, энэрэхүй, асрахуй сэтгэл, бусдын буянд даган баясах сэтгэл дээр суурилсан боди сэтгэлийг олоод, хоосон чанарыг оноод хамаг амьтны тусын тулд гэгээрэлд хүрэхийг зорилгоо болгодог. Бурхан багш хүн төрөлхтний түүхэнд анх удаа дөрвөн үнэн, найман мөр, нисваанис, үйлийн үр, боди сэтгэлийг олох, шүтэн барилдлага, хоосон чанарын тухай гайхамшигт сургаалыг айлдсан. Бурхан багшийн сургаал бол оюун ухааны тухай бүхэл бүтэн цогц шинжлэх ухаан юм. Бурханы шашин бол гэгээрлийн тухай сургаал юм. Бурханы шашин бол авралын тухай сургаал гэж ойлгож болно. Бурхан багшийн сургаалд “хэн нэгэн лам багш бусад хүний нүглийг үүрч ариусгаж чадахгүй, харин зөвхөн тухайн хүн өөрөө нүглээ ариусгаж, үйлийн үрийг таслаж, сахил авч гэгээрлийн замд орж, оюун ухааны өндөр түвшинд хүрч, лам багшийг шүтэж байж бурханы хутгийг олно” хэмээн үздэг.

Бурхан багш хэлэхдээ: “Хүний ухамсрыг гурван хор хордуулж байдаг. Энэ нь мунхаглал, шунал, уур юм. Хүн өөрийн сэтгэлд бугшсан уур, шунал, хорон санаа, үзэн ядалт, атаа жөтөө, мунхаглал, эргэлзээ, хардалт, сэтгэл дундуур байдал, омог бардам зэрэг сэтгэлийн 84 000 өвчин буюу нисванисийг танин барьж устгах хэрэгтэй” гэжээ. Хүн аз жаргалтай байхын нөхцөл шалтгааныг өөрөө бүрдүүлэх нь чухал. Энэ нь арван цагаан буян үйлдэж, бусдын тусыг бодож, буянаа хураахыг хэлнэ. Ингэж байж эерэг үйлийн үрийг буй болгоно, амар амгалан жаргалыг бүрдүүлнэ” хэмээн сургадаг.

Бурханы шашны сургаалыг 15-20 жил сайн лам багшаар заалгаж байж эзэмшдэг ажээ.

Бурхан багшийн сургаал бол Ганжуурын 108 боть, Данжуурын 224 ботид багтсан асар өргөн хүрээтэй айлдвар билээ. Бурхан багшийн сургаалыг нөр их хөдөлмөр, хичээл зүтгэл, тэвчээр гаргаж байж өөрөөр хэлбэл, зургаан билиг барамидийг эзэмшиж байж сурдаг. Тиймээс орчин үеийн бурхан шашны сүм хийд нь сүсэгтнүүдийг ийм нарийн эрдэм ухааны гүнд нэвтрүүлэх боломж бага байдаг юм гэхэд түүний сургаалын агуулгын ерөнхий санаа, гол утга, үүрэг, зорилгыг тайлбарлаж таниулах нь чухал хэмээн үзэж байна. Ингэснээрээ номын утгыг ойлгож шүтэх нь сүсэгтнүүдийн биеэ авч явах хэм хэмжээ, ёс суртахууны төлөвлөөс эхлээд шашны боловсролд нөлөөлж, улмаар нийгмийн өмнө гүйцэтгэх үүргээ биелүүлэх нөхцөл бүрдэнэ хэмээн үзэж байна. Сүм хийд, сүсэгтнүүдийн жинхэнэ харилцаа үүнд оршино.

Орчин үеийн цахимжсан ертөнцөд сүм хийдүүд сүсэгтнүүдэд зориулсан буддын шашны ойлголт, зарчим, зорилго, ач холбогдлыг тайлбарласан орчин үеийн шаардлага хангасан сайн веб сайт ажиллуулж, сүм хийдийн харилцааг сайжруулж, сүсэгтнүүдээ төлөвшүүлэхэд анхаарах шаардлагатай. Хэдийгээр Монголын бурханы шашины төв Гандан хийд веб сайттай боловч тэр нь мэдээллээр ядмаг, багтаамж муутай, олон сарын өмнөх мэдээ нь өөрчлөгддөггүй байх нь сүсэгтнүүдэд төдийлөн сайн мэдээллээр хангах орчинг бүрдүүлж чадахгүй байгаа юм. Гандан хийд болон бусад хийд Буддизмын тухай англи, орос, түвд, энэтхэг веб сайтуудын туршлагыг нэвтрүүлэх хэрэгтэй. Нэг жишээ татахад өнөөдөр ОХУ-ын “SaveTibet.ru” веб сайт нь дэлхийн буддизмын хамгийн сүүлийн үеийн шинэ мэдээ, судар, ном, видео, аудио мэдээ, баримтат кино, Далай лам багшийн ном тавьсан тухай мэдээллийг газар дээрээс нь орос хэл дээр хөрвүүлэн шууд дамжуулдаг нь дэлхийн буддистуудын талархлыг хүлээдэг билээ. Энэхүү туршлагыг монголчууд нэвтрүүлэх хэрэгтэй.

XX зууны их багш Ошо “Сэтгэцийн өвчтэй хүмүүс л архи, тамхи, мансууруулах бодист донтдог юм” хэмээн хэлжээ. Өнөөдөр Монголд сэтгэцийн өвчтэй хүмүүс, архичид, гэмт хэрэгтнүүдийн тоо улам ихсэх болжээ. Монголд нэг жилд 1500 хүн гэмт хэргээс болж үхэж байгаа нь XX зуунд Монголын цэрэг 4 удаагийн дайнд орж үрэгдсэн тооноос ч их байна. Өнөөдөр Монголд амьтны амийг таслах бүү хэл, алаг үрсийнхээ амийг таслагчдын тоо улам өсч, албан мэдээгээр нэг жилд улсын эмнэлэгт 15000 хүүхэд үр хөндөлтөд өртөж хорвоог орхиж байна. Хүүхэд эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөж, золбин хүүхдүүд гудамжинд амьдарч байна. Иймд нийгмээ эрүүлжүүлж энэрэнгүй болгоход Буддын шашны гүйцэтгэх үүрэг их байх юм.

Үндсэн хуулиндаа “хүмүүнлэг нийгмийг байгуулна” гэж заасан нь сүм хийдийн сүсэгтнүүдэд зориулсан үйл ажиллагаа, түүний үүргийг нэмэгдүүлсэн хэрэг мөн. Тиймээс боловсролын байгууллагаас эхлээд шашны төрөлжсөн байгууллагууд хамтран сүсэгтэн олны дунд зөв амьдрах арга ухааныг сурталчлах ажлыг хийх шаардлагатай. Ингэснээрээ өсвөр залуу үеийнхэнд бодь сэтгэл, тэгш сэтгэл, энэрэхүй сэтгэл, асрахуй сэтгэл, бусдын буян амжилтанд даган баясах сэтгэлтэй болгох талаар ойлголттой болж сүсэгтэн сүм хийдийн харилцаанаас илүү сүсэгтэн сүсэгтний хоорондын харилцаанд эерэг өөрчлөлт гарах ба энэ нь нийгмийн эрүүл харилцааны үндэс болох билээ.

Сэтгэлээ хэрхэн жолоодож чаддаг болох, сэтгэлээ хэрхэн ариусгах талаар буддын гүн ухааны хичээлээс гадна зургаан билиг барамидийг хэрхэн эзэмших талаар зааж өгөх хэрэгтэй. Энэ нь үндэсний уламжлалт соёл, шашныг өсвөр залуу үед бага, дунд сургуульд орох үеэс нь эхлэн зааж сургах нь чухал асуудал болоод байна. Бурхан багшийн сургаал, монгол ардын ёс заншил, үндэсний уламжлалт соёлыг орчин үеийн техник технологи, шинжлэх ухаантай хослуулан залуу үедээ өвлүүлж байж энэхүү зорилгодоо хүрнэ. Үндэсний шашин, соёлоо ч өсвөр үедээ ойлгуулж зааж сургасангүй нь нэг талаас төрийн бодлого, нөгөө талаас үндэсний шашны үйл ажиллагаа, тэдний зорилтот бүтээлч үйл ажиллагаа сул, шашны нөлөө бүхий зүтгэлтнүүдийн нийгмийн оролцоо сул, байлаа ч сурталчилгаа хомсдолд орсны илрэл мөн. Энэ бүхнээс дүгнэн хэлбэл, 1990 оноос хойш сүм хийдийн үйл ажиллагаа идэвхжиж,

сүсэгтнүүд шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэх сайхан боломж бүрдсэн хэдий ч сүм хийд хийгээд сүсэгтнүүдийн харилцаа нь нийгмийн хөгжилд ахиц дэвшил авчрахуйц бодит утгаараа хэрэгжиж чадахгүй байна.

Орчин үеийн монгол хүн нь хүн төрөлхтний мэдлэг боловсролоос суралцаж, үүний сацуу үндэсний уламжлалт шашин, соёл, зан заншил, бичгээ мэддэг хүнийг хэлнэ. Зарим хүн "тэр хоцрогдсон уйгуржин монгол бичгээр яах юм бэ?" гэх юм. Улаантнууд уйгуржин монгол бичгийг устгасан шалтгаан нь монгол хүнийг шашин соёлоос нь таслахын тулд, монгол хүн уйгуржин монгол бичгээрээ Ганжуурын 108 боть, Данжуурын 224 ботийг болон олон монгол гайхамшигт судар номыг уншиж чадахгүй болгохын тулд, эх хэл түүх соёлыг нь мартуулахын тулд хийсэн хэрэг гэж ойлгодог. Ийм учраас бид уйгуржин монгол бичгээ заавал сурах хэрэгтэй. Бурхан багшийн үнэний ариун сургаалыг монголын хүүхэд залуучуудад дунд сургууль, их дээд сургуульд сурч байхаас нь эхэлж энгийн ойлгомжтой, логик дэс дараалалтай заан сургах хэрэгтэй. Буддын судлалын эрдэмтэд, мэргэшсэн лам хуваргууд, сүм хийдийн зүтгэлтнүүд сүсэгтнүүдийн сүсэг бишрэлийн төдийгүй оюун санааны хэрэгцээг хангахуйц шинжлэх ухаан, Буддын ухааныг хослуулсан сурах бичиг, ном зохиолыг энгийн ойлгомжтой хэлээр бичих шаардлага нэн тэргүүнд тулгарч байна.

Түүнчлэн сурагч, оюутнуудад үндэсний шашны сургаалыг тусгай хөтөлбөрийн дагуу сонирхолтой зааж чаддаг багш нар хэрэгтэй байна. Өнөөгийн боловсролын байгууллагын багш нар "сурагч бүр үнэнч шударга, ёс зүйтэй, өв тэгш хүмүүжилтэй хүн болох хэрэгтэй" хэмээн ерөнхий зүйл ярьж сургацгаадаг. Хэрэв сургуулиудад бурхан багшийн энгийн хүмүүст сургасан таван сахилын тухай сургаалыг зааж төлөвшүүлсэн бол хүн бүр:

- амьтны амийг тасалдаггүй,
- хулгай хийдэггүй,
- садар самуунд автдаггүй,
- худал хэлдэггүй,
- архи уудаггүй" болж хүмүүжинэ.

Буддын шашны сургаалаар гэлэн лам хүн 253 сахилыг сахидаг бол дээр нэрлэсэн таван сахилыг сүсэгтэн хийгээд нийт хүмүүст зааж сургаж, ойлгуулж чадвал бүх хүн сахиж чадна. Энэ бол нийгмийн амар амгалангийн үндэс болох юм.

Далай багш "Орчин үеийн Монгол Улс бол дэлхийн Буддизмын тулгуур юм" хэмээн айлдсан. Иймд орчин үеийн Монгол Улс дэлхийн Их Хөлгөний төв, дэлхийн бурханы шашны төв нь болох боломжтой. Эдүгээ эрх чөлөө, тусгаар тогтнолоо олсон шинэ Монгол Улс нь ойрын ирээдүйд бурханы шашин соёлын үүрэг ач холбогдлыг нэмсэн, түүнийг ойлгосон, өндөр хөгжилтэй, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлсэн ардчилсан орон болох хэрэгтэй. Ийм улс болох эсэх нь монгол төрийн зөв бодлого, лам нарын эрдэм ном, зөв үлгэр дууриалал, монголчууд бидний хичээл зүтгэл, эв нэгдэл, энэрэнгүй сэтгэл, эх оронч зориг тэмүүллээс хамаарах болно.

Энэ бүхнийг дүгнэн хэлэхэд, Монгол орон 1990 оны үеэс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэнээр Бурханы шашныг сэргээн дэлгэрүүлэх төрийн бодлого хэрэгжих боломжтой болсон хийгээд сүсэгтэн олны дэмжлэгтэйгээр сүм хийд, сүсэгтнүүдийн харилцаа дахин сэргэж, шүтэх эрх, эрх чөлөө баталгаажсан юм. Үүнтэй зэрэгцэн сүүлийн 30 шахам жилд өөр өөр шашны урсгал чиглэлүүд нэвтрэн орж ирсэнээр зонхилох байр суурь бүхий шашны хувьд өөрийн сургаалын мөн чанар, зан үйлийг сүсэгтэн олонд улам бүр зөвөөр ойлгуулах, Буддын сүм хийдийн үйл ажиллагааг шинэ төвшинд хүргэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

ABSTRACT

Although Mongolia's Buddhist monasteries have experienced a revival, the relationship between the laity and Buddhist monastic communities has been rekindled and the freedom of religion has been guaranteed since 1990s, the unsatisfactory state of the Buddhist monasteries' lasting impact on society's spiritual cultivation could be attributed to the lack of their active engagement with the lay people. The purpose of stimulating an active engagement with the laity on the part of Buddhist monastic communities is to promote spiritual cultivation of the society as a whole; nurture younger generation to become compassionate, caring, unprejudiced, and humane persons; educate young people on Buddha's teachings on attaining bodhicitta; strengthen national unity; provide help and emotional support to people struck by illness and suffering; and protect the environment.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992
2. Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ.,1993
3. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.,2010
4. Ажаа гэгээн. “Цагийг бэлэгдэгч Наран Чөлөө”. УБ., 2009
5. Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй. УБ.,2016 I-V боть орч., С.Гантөмөр
6. Ч.Р.Бауден. Монголын орчин үеийн түүх. УБ.,2018
7. М.Гантуяа. “XXI зууны Монголын нийгэм: хөгжил, өөрчлөлт, хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэл. МУИС. УБ., 2015-01-15
8. Б.Даш-Ёндон. Нийгмийг танихуй: түүх – хөгжлийн философи. УБ.,2014
9. Г.Дашням, Т.Билэгсайхан нар. Монголын цагаагчин гахай жилийн хувьсгалын түүхийн чухаг сурвалж. УБ.,2011
10. Лам нарын сэтгүүлийн цувралууд. УБ., 2010-2012
11. С.Цэдэндамба. Монгол Улс дахь шашины нөхцөл байдал (XX-XIX зууны зааг үе). УБ.,2003
12. Шашин судлал. УБ.,2001. Ред., Д.Дагвадорж
13. Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө. Эмхэтгэсэн М.Гантуяа. УБ.,2004